



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 5/18

Чингис хот

Ажлаас чөлөөлж, түр орлон
гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.3, 3.3.1, 4.2, 4.2.3, 4.4, "Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам"-ын 5.11-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Агентлагийн хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Гантөгс нь өөр ажилд шилжин ажиллах болсон тул 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Агентлагийн хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан мэргэжилтнийг томилогдох хүртэлх хугацаанд Нутгийн захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Ганчимэгийг албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

3. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Ч.Баярцолмон

-Хяналт шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Ганчимэг

-Хяналт шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн

Т.Бямбадулам

-Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа

-Нярав

4. Б.Гантөгстэй холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР